



МУИС-ийн удирдлагын багийн нэг жилийн хугацаанд хийж бүтээсэн гол гол ажлуудаас

ТАЙЛБАР: МУИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар, дэд захирал Б.Очирхуяг, Бал.Очирхуяг, Ч.Ундрэм, Ц.Болормаа нар ажлаа аваад нэг жил болж буйтай холбогдуулан энэхүү явцын тайлангаа нээлттэй толилуулж байна

Улаанбаатар хот
2018 он


МУИС-ийн удирдлагын баг бүрдээд нэг жилийн хугацаанд богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017 оны 3 дугаар сарын 17-ноос 2017 оны 6 дугаар сарын 15 хүртэл, 2017-2018 оны хичээлийн жилээр, 2018 оны календарийн жилээр тус тус төлөвлөн ажиллаа. Энэ хооронд 2017 оны МУИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн БСШУЯ-тай байгуулсан Үр дүнгийн гэрээг тайлагнаж 97 оноогоор үнэлэгдсэн нь удирдлагын баг хамт олны ажлын үр дүн хэмээн үзэж байна. Нэг жилийн хугацаанд бид өдөр тутмын ажлын зэрэгцээ олон өөрчлөлт шинэчлэлтийн томоохон ажлуудыг санаачлан хийж бүтээсэн байна.

Захиргаа, хүний нөөцийн чиглэлээр

- ❖ МУИС-ийн дүрмийг шинэчлэн боловсруулж 2017 оны 6 сарын 14-ны Удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан. Мөн МУИС-д мөрдөгдөж буй журам, эрх зүйн бичиг баримтуудыг үе шаттай цэгцэлж байна. Үүнд:
 - ❖ МУИС-ийн шагнал урамшууллын нийтлэг журам
 - ❖ МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам
 - ❖ МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам
 - ❖ МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам
 - ❖ Номын сангийн журам
 - ❖ МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2018 онд оюутан элсүүлэх журам
 - ❖ Эрдмийн музейн журам
 - ❖ МУИС Пресс төвийн журам зэргийг сайжруулан шинээр боловсруулсан.
- ❖ АХБ, ДБШТ-ийн хүрээнд Захиргааны бүтцийг 2017 оны 9 сарын 6-ны Удирдах зөвлөлийн хурлаар шинэчлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.
- ❖ Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж мөрдлөг болгон ажиллаж байна.



- ❖ 2017-2018 оныг Багшийн хөгжлийн жил болгон зарлаж Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулсан бөгөөд хэлэлцүүлэх шатандаа явж байна.



- ❖ МУИС-ийн 75 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн Төрийн дээд шагнал Сүхбаатарын одонг 60 жилийн дараа хүртэв.



- ❖ МУИС-ийн түүхэнд анх удаа Эрдмийн музей байгуулж, багш, ажилтан, төгсөгчдөөс үзмэр бүрдүүлж үйл ажиллагаагаа эхлүүллээ.



- ❖ 2016-2017 оны хичээлийн жилийн тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж Удирдах зөвлөлд хүргүүлэв.



- ❖ БМИУЗ-өөр МУИС-аа 3 дах удаагаа магадлан итгэмжлүүлэхээр тайлангаа хүлээлгэн өгч урьдчилсан дүгнэлтээр "бүрэн хангасан" үнэлгээ авлаа.



Захиргаа, хүний нөөцийн чиглэлээр

- ❖ Хүний нөөцийн мэдээллийн системийг сайжруулах зорилгоор системийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж нэвтрүүлэх ажил эхлэв.



- ❖ Багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах бэлтгэл ажил хангагдсан.
- ❖ Захиргааны бүх нэгж, хүрээлэн, төвийн удирдлагаар ажлын тайлан тавиулж, үйл ажиллагаагаа сайжруулах зөвлөмж, чиглэл өгч гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.
- ❖ Эдийн засгийн хүрээлэн, Гадаад харилцааны хэлтэс, МУИС Пресс төв, Оюутны хөгжил, үйлчилгээний газар, Сургалтын нэгдсэн газарт Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үүрэг, хариуцлагыг чангатган ажиллаж эхлэв.
- ❖ Стандартчилал, хэмжил зүйн газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажил хийгдэж байна. Мөн 2018 ондоо багтаад QS ranking зэрэглэл тогтоолгох ажлыг эхлүүлэхээр зорин ажиллаж байна.



- ❖ МУИС-ийн ЗХНГ-аас Шинэ ажилтнуудад зориулсан чиглүүлэх сургалтыг анх удаагаа зохион байгуулсан.



- ❖ МУИС-ийн ЗХНГ, БХЦСТ-тэй хамтран Шинэ багш нарт зориулсан чиглүүлэх сургалтыг анх удаагаа зохион байгуулсан.



- ❖ Удирдлагуудтай үр дүнгийн гэрээг КРІ шалгуур үзүүлэлтээр байгуулав.



- ❖ МУИС-ийн 75 жилийн ойн хүрээнд 351 багш, ажилчдыг байгууллагын болон Засгийн газар, төрийн одон медалиар шагнуулахаас гадна гэр, эд материаллаг зүйлсээр шагнаж нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:

- ❖ Төрийн одон медаль – 53
- ❖ Засгийн газрын шагнал – 117
- ❖ МУИС-ийн шагнал – 108
- ❖ Материаллаг урамшуулал – 27 /үүнээс 15 хүнд гэр, 12 хүнд цахилгаан бараа/




- ❖ Төрийн дээд одон, медалиар шагнуулсан багш, ажилтанд хүндэтгэл үзүүлж хэвшив.




Мэдээллийн технологийн чиглэлээр

МУИС-ийн сүлжээний дэд бүтэц, техник хангамжийг сайжруулах

- ❖ Сүлжээтэй холбоотой тоног төхөөрөмжийн бүртгэлийг шинэчлэв.
- ❖ Шинэ номын сангийн сүлжээний дэд бүтцийг хийв.
- ❖ Байр хоорондын сүлжээний холболтыг өндөр хурдны 48 корын шилэн кабелиар холбов.




- ❖ Утасгүй сүлжээний мониторинг, хяналтын системийг үүсгэн ажиллагаанд оруулав.



- ❖ МУИС-ийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, удирдлагын мэдээллийн систем нэмэгдэн сайжирсантай холбогдуулан Dell 930 сервер, Dell NX3230 хадгалах серверээр хүчин чадлыг нэмэгдүүлэв.




- ❖ Хяналтын камерын системийг сайжруулж, камерын тоог нэмэгдүүлж, техникийн үзүүлэлтийг сайжруулав.



- ❖ Шинэ номын сангийн барилгад байрлах серверийн өрөөг хөргөлт болон орчны хяналтын системээр хангагдсан серверийн кабинет систем бүхий орчныг бий болгов.



- ❖ Интернетийн хурд 100Mbps-аар нэмэгдүүлж, интернэтийн давхар гарцтай боллоо.



СИСи сургалт, удирдлагын мэдээллийн систем

- ❖ Судалсан хичээлийг улирал болон төлөвлөгөөгөөр харуулсан дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийн хуудсыг нэвтрүүлснээр хос, хавсарга мэргэжлээр суралцагчийн дүнгийн болон төлбөрийн тулгалт хийх үед үүсэж байсан асуудлыг шийдэв.

Боломжит үйлдлүүд

- Сонгох
- Засварлах
- Зөвшөөрөл
- Дүнгийн мэдээлэл
- Дүнгийн дэлгэрэнгүй

Төлөвлөгөө: Бүгд

- Бүгд
- Бизнесийн сургуулийн ерөнхий суурь хөтөлбөр(Үндэс)
- Бакалавр/Бадрийн сургалт
- Самуу, Банк(Үндэс)
- Бакалавр/Бадрийн сургалт
- Хөтөлбөрт тосгогдоогүй хичээл зарах

Аль хөтөлбөрт хичээл сонголт хийсэн

Бүртгэгдсэн гүйцэтгэлийн мэдээлэл

№	Хичээлийн жил	Хичээлэх Улирал	Хөтөлбөр	Тайлбар	Орлого	Зардал	Бүтэц
1	2017-2018	Нягран уулрал	Самуу, Банк	Орлогогүй хичээлээр төлбөр үлэсэн	1321000	1321000	
2	2017-2018	Нягран уулрал	Самуу, Банк	"Самуу, Банк" хичээлээр төлбөр үлэсэн		244200	
3	2017-2018	Нягран уулрал	Самуу, Банк	"Урсгалын зардал" хичээл үлэсэн		244200	
4	2017-2018	Нягран уулрал	Самуу, Банк	"Самуу, Банк" хичээлээр төлбөр үлэсэн		244200	

Мэдээллийн технологийн чиглэлээр

Мэдээллийн системд орсон өөрчлөлт, хийгдэж буй мэдээллийн систем

- ❖ Суралцагчийн англи хэлний зохих (ахисан дунд) түвшний шаардлага хангасан эсэхийг шалгах систем хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэв.

- ❖ Гадаад дотоод хамтын ажиллагаа, гэрээний бүртгэлийн системийн хөгжүүлэлтийн ажил хийгдэж, хамтын ажиллагаатай гадаад, дотоодын байгууллага, гэрээг бүртгэх системийг хөгжүүлж, нэвтрүүлэх ажил хийгдэж байна.

- ❖ Хэрэглэгчдээс ирсэн санал, хүсэлт, дуудлагыг бүртгэлжүүлж ангилах, хариуцах ажилтанд хүргэх, үр дүн бүртгэх, тайлан статистик гаргах дуудлага бүртгэх системийн хөгжүүлэлт хийгдэж байна.

- ❖ Мэдээллийн системийн хэрэглэгчдээс тухайн мэдээллийн системийн орчноос үүссэн асуудал, санал хүсэлтийг хүлээн авах, эргэх холбоо үүсгэх зорилготой plugin-ийг дурын систем шууд ашиглахад тохиромжтой байхаар шийдвэрлэв.

- ❖ СИСи мэдээллийн системийн сургалтын төлбөрийн модулийг татварын Е-Баримт-ийн системтэй холболоо.

Дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах чиглэлээр

- ❖ Тогтвортой хөгжил-Дээд боловсрол улсын II зөвлөгөөнийг БСШУСЯ-тай хамтран зохион байгуулж өндөр үнэлгээ авав.



- ❖ МУИС-ийн Ахмадуудын нэгдсэн холбоог байгуулж МУИС-ийн Ахмад багш, ажилтны анхдугаар чуулганыг зохион байгуулав.



- ❖ Төгсөгчдийн холбоог шинэчлэн идэвхжүүлж хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж эхлэв.




- ❖ 12 агентлаг, 17 аймгийн Засаг дарга, 4 төрийн томоохон байгууллага, 4 хувийн хэвшил, 5 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ, санамж бичиг байгуулан ажиллаж байна.



- ❖ Их сургууль аж үйлдвэрийн хамтын хөгжил форум зохион байгуулж аж үйлдвэрийн байгууллагуудтай хамтран ажиллах санал санаачилгыг дэмжин ажиллаж байна.



- ❖ МУИС-ийн БС-ийн багш нарын хийсэн судалгааны үр дүн, нэмэлт хэлэлцүүлэг, гадаадын их сургуулиудын туршлага судалсны үндсэн дээр МУИС-ийн анхны Маркетингийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэв.
- ❖ МУИС-ийн цахим мэдээллийг шинэчлэх ажлын хэсэг байгуулж хуучирсан, давхардсан мэдээллийг цэгцлэхийн зэрэгцээ шинэ мэдээллүүдийг нөхөж оруулав.



- ❖ МУИС-ийн амжилт бүтээлийг сурталчилсан. Өөрсдийн мэдээ, мэдээллийг цахим хуудас, социал хаягуудаараа хүргэхээс гадна Өнөөдөр сонин, МОНЦАМЭ зэрэг хэд хэдэн байгууллагатай хамтран ажиллан олон нийтэд түгээж байна.
- ❖ Олон улсын олимпиад, уралдаан, тэмцээний амжилтын тухай “Амжилтын түүхээ”, МУИС-ийн түүхэн хөгжил нэртэй нэвтрүүлэг, баримтат кино бүтээж МҮОНРТВ, Блүүмберг, SBN зэрэг телевизээр олон нийтэд мэдээлсэн.

Эрдэм шинжилгээ, инновацийн чиглэлээр

- ❖ “Судалгааны их сургууль” хэлэлцүүлгийг төрийн өмчийн их сургуулиуд болон УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, БСШУСЯ-тай хамтран зохион байгуулав.



- ❖ “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”, “Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай хууль”-ийн шинэчлэлд өгөх саналыг боловсруулж БСШУСЯ-д хүргүүлэв.
- ❖ “МУИС-ийн судалгааны лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журам”, “МУИС-д бүртгэлтэй дотоодын сэтгүүлүүдийн үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийг БС-ийн ЭЗ-өөр хэлэлцүүлж байна. “МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журам”-ыг боловсруулж байна.
- ❖ “Б цагийн үнэлгээний аргачлал” хэлэлцүүлж дууссан.
- ❖ ЭШММС дээр технологи задлах өргөтгөл хийсэн. Оюуны өмчийн мэдээллийн сан Excel файлаар үүсгэсэн. Цаашид цахим болгох техник даалгавар боловсруулна. ОӨГ-тай хамтарсан сургалтыг 3 дугаар сард хийсэн.



- ❖ Азийн хөгжлийн банкны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилттэй судалгааны 13 төслийн хүрээнд Хэрэглээний математик, био инженерчлэл, генетик инженерчлэлийн томоохон салбар дамнасан судалгааны баг бүрдүүлж байна. 2018 онд АХБ-аас зочин судлаачийн 60 сая төгрөг, өндөр түвшний 10 төсөлд 192.5 сая төгрөг, залуу судлаачдын багийн 8 төсөлд 76.6 сая төгрөг, профессор, дэд профессор судалгааны суурь зардалд 373 сая төгрөг төсөвлөн ажиллаж байна.

- ❖ Clarivate Analytics компанийн арилжааны патентын хайлтын Derwent World Patents Index (DWPI) системийг 2017 оны 4 дүгээр сард нэг жилээр нээж, патентын бүрэн эхийг унших боломжтой болгов.




- ❖ Clarivate Analytics компанитай Web of Science -ыг жилд 2 сар үнэгүй нээх гэрээг 2018 оны 4 дүгээр сарын 2-д байгуулж, олон улсын сертификаттай сургалтыг 2018 оны 4 сарын 2-3-д зохион байгуулав.
- ❖ 2018 оны 1 дүгээр сард Springers Laboratory Protokols мэдээллийн санг 2 сараар үнэгүй нээв.




- ❖ Cortellis био анагаахын зах зээлийн санг Томсон Инновейшн компаниас 2 сараар үнэгүй нээхээр ажиллаж байна.



- ❖ Монголын анхны хиймэл дагуулыг МУИС-ийн багш, судлаач Д.Эрдэнэбаатар, Т.Төртогтох, Д.Амартүвшин нар бүтээсэн.



- ❖ Мазаалай хиймэл дагуул хөөргөх үйл явцтай холбоотой Мазаалай тойрог замд, Мазаалай хиймэл дагуул бүтсэн түүх гэсэн 2 баримтат нэвтрүүлгийг бэлтгэсэн.



Эрдэм шинжилгээ, инновацийн чиглэлээр

- ❖ Их сургууль-Бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор ТЭСО ХХК, Витафит ХХК, Гацуурт ХХК, МАК ХХК-тай уулзалт МУИС-аас санал болгож буй биотехнологи, нүүрсний хими, цэвэр энергийн технологийн чиглэлээр санал солилцож “Монгол улсын нүүрсний салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагын нийлүүлэлтийн гинжин хэлхээний менежментийг боловсронгуй болгох” төслийн санал хүргүүлэв.



- ❖ Их сургууль – Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны хүрээнд IT zone, Багануур компанитай хэлэлцүүлэг зохион байгуулж хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Хэлэлцүүлгийн үеэр хамтарсан болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажил гүйцэтгэх, шинэ технологи хөгжүүлэх, хамтарсан гарааны компани байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг ажлыг хэрэгжүүлэх болж, Багануур компаниас профессор А.Энхбаяр 30 сая төгрөгийн төсөл авснаар хамтын ажиллагаа бодитоор хэрэгжиж эхэллээ.




- ❖ МУИС-ийн гарааны компанийн журмын хоёр удаагийн хэлэлцүүлгийг хийж МУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж байна.



- ❖ МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс, Технологи Дамжуулах Төв, ХШУИС-ийн Машин оюуны лаборатори, Бизнесийн сургуулийн Бизнес Консалтинг Төв хамтран зохион байгуулсан МУИС Стартап Лаб (MUIS Startup Lab) хөтөлбөр бүтэн 3 сар хэрэгжиж, 9 сарын 23-ны өдөр Demo Day буюу хаалтын өдөрлөгөө хийсэн.




- ❖ АДБ-ДБШТ-ийн хүрээнд хэрэгжсэн “Ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэл” нэр бүхий инновацийн төслөөр МУИС-ийн гарааны компани Эм Би Пи Лаб ХХК байгуулж анхны лицензийн гэрээг 2018 оны 3 сарын 23-ний өдөр байгуулав.



- ❖ “МУИС-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журам”-ын хэрэгжилтийн хүрээнд МУИС-ийн Бизнесийн сургуулийн дэргэдэх Бизнес Консалтинг төвд МУИС-ийн барааны тэмдгийг ашиглуулах гэрээг 2018 оны 3 дугаар сарын 7-ны өдөр байгуулж тус төвийн дэлгүүрээр борлуулж байгаа бараан дээр хэвлэн борлуулж байна.

Сургалт, оюутан

- ❖ Сургалтын нэгдсэн газар, Оюутны хөгжил үйлчилгээний газрын бүтцийг шинэчлэн зохион байгуулж ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийг сайжруулсан.



Хөтөлбөр, чанарын баталгаажуулалт

- ❖ Хөтөлбөрийн ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг 2017 оны 11-р сарын 23-ны өдрийн А/370 тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд энэ хугацаанд 3 удаа хуралдаж бакалаврын 3, магистрын 3, докторын 1 хөтөлбөрүүдийг шинээр нээхийг дэмжиж, урьдчилсан магадлан итгэмжлүүлэх шийдвэр гаргасан.



- ❖ Ерөнхий суурийн хичээлүүдээс хичээл сонголтын дүн, нэгжийн хөтөлбөрийн хорооны саналыг үндэслэн 2 хичээлийг хасаж, шинээр 4 хичээлийг Ерөнхий суурьд оруулахаар тогтоосон.
- ❖ Ерөнхий суурь хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, хичээлийн хэлбэр, үнэлгээ, заах арга, сургалтын орчин нөхцөлд үнэлгээ хийж, хичээлүүдийн чанар, үр дүнд хяналт шинжилгээ хийж цаашид сайжруулах эсвэл хасах санал, зөвлөмжийг боловсруулах зорилготойгоор Ерөнхий суурь хөтөлбөрийн хичээлийн үнэлгээний ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
- ❖ Олон улсын магадлан итгэмжлэлээр орж байгаа програм хангамж, хими хөтөлбөрүүдэд нэмэлт санхүүжилтийг БСШУСЯ-нд тавьж шийдвэрлүүлэв.

- ❖ 2017-2018 оны хичээлийн жилд ХШУИС-ийн Мэдээллийн технологи, Программ хангамж хөтөлбөрүүд олон улсын магадлан итгэмжлэлийн ASIIN-аар, Мэдээллийн технологи хөтөлбөр Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөлөөр магадлан итгэмжлэгдэв. Энэ хичээлийн жилд дотоодын магадлан итгэмжлэлд 11 хөтөлбөр орж, өөрийн үнэлгээний тайланг БМИУЗ-д хүлээлгэн өгөв.




- ❖ Хөтөлбөрийн үндсэн сурах бичиг бий болгоход дэмжлэг үзүүлэх 100 сая төгрөгийг төсөвт суулган хэрэгжүүлэхээр бэлтгэл ажил эхлүүлэв.
- ❖ **МООС** (Massive Open Online Course) буюу **Нийтэд Нээлттэй Онлайн Хичээл** (ННОХ)-ийн платформтой болж, “Инженерийн математик”, “Электроникийн үндэс” хичээлүүдийг 2017 оны 11-р сарын 1-ээс эхлүүлж, нийтийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж эхэллээ.



- ❖ ШУТИС, МУБИС, ХААИС, СУИС-тай хамтран «Ахисан түвшний CDIO» хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болов. Уг хөтөлбөрийн стандарт арга зүйн сургалтад хамрагдаж сургагч багш, хэрэгжүүлэх багтай болж, “Электроникийн инженерийн хөтөлбөр” боловсруулсан. Цаашид “Ойн инженер”, “Хүрээлэн буй орчны инженер”, “Химийн инженер” хөтөлбөрүүдэд тус аргачлалыг нэвтрүүлэхээр, төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- ❖ Европын Холбооны санхүүжилттэй (Erasmus+) оюутны шилжилт, хөдөлгөөнийг зохион байгуулах, кредит дүйцүүлэлт хийх аргачлал боловсруулах “PAWER” төсөл, ногоон байгууламжид, мэдээллийн технологи, инженерийн шийдлийг тусгах мэргэжилтэн бэлтгэх зорилго бүхий “GREB” төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна.

Элсэлтийн үйл ажиллагаа, сургалтын маркетинг

- ❖ 2017 онд бакалаврын өдрийн хөтөлбөрт нийт 3,466 оюутан элсэн суралцсан.



- ❖ 2017-2018 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрт бүртгүүлэгчдийн тоог 2016-2017 оны хичээлийн жилтэй харьцуулахад 20.1 хувиар өссөн байна.



- ❖ 2017-2018 оны хичээлийн жилийн жилд МУИС-ийн докторын хөтөлбөрт бүртгүүлэгчийн тоо нь өнгөрсөн жилийнхээс 12.7 хувиар, элсэгчдийн тоо 12.9 хувиар тус тус өссөн бөгөөд гадаад оюутны элсэлтийн тоо 33.3 хувиар нэмэгдэв.



Сургалтын бүртгэл

- ❖ МУИС-ийн хэмжээнд хуучин хөтөлбөрөөр суралцаж байсан бакалаврын түвшний 1,768 оюутныг шинэ хөтөлбөрт шилжүүлэх шаардлагатайгаас 1,481 оюутны хичээлийг дүйцүүлэв. Идэвхгүй төлөвт байгаа оюутнуудын дүйцүүлэлт болон ахисан түвшний хөтөлбөр шилжүүлэлтийн бэлтгэл ажил явагдаж байна.
- ❖ Зарим бүрэлдэхүүн сургуульд бүртгэлийн мониторинг хийж үүссэн зарим зөрчлүүдийг (дүн завсарлах, төлөв өөрчлөх) арилгаж, холбогдох хүмүүст сахилгын арга хэмжээ тооцсон.
- ❖ Хичээлийн хуваарийн дагуу багшийн хичээлийн цагийг хянах ажлыг зохион байгуулснаар багш нар чөлөөний хуудсаа цаг тухайд нь бөглөх, хичээл тасарсан цагаа нөхөж орох нь сайжирлаа.
- ❖ Сургалтын анги танхимын тоо 233 болж нэмэгдсэн (2016-2017 онд хичээлийн ангийн тоо 214 байв).
- ❖ Хавсарга хөтөлбөрөөр суралцсан төгсөгчдийн гэрчилгээний загварыг шинээр батлав.
- ❖ Бакалаврын төгсөлтийн диплом, дипломын хавсралтыг олон улсын шаардлагад нийлүүлэн сайжруулав.

Оюутан

- ❖ Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо, тэтгэлэг олгосон байгууллагын тоо тус тус нэмэгдэв. 2017 онд 19 байгууллагаас 317 оюутанд тэтгэлэг олгосон бол 2016 онд 13 байгууллагаас 211 оюутанд тэтгэлэг олгож байв. МУИС дотоод эх үүсвэрээр 87 оюутанд тэтгэлэг олгоод байна. Энэ хугацаанд нийт 33 оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдав.



- ❖ Гадаад оюутны тоо энэ хичээлийн жилд 433 хүрсэн байна. 2016 онд 383, 2015 онд 332 гадаад оюутан суралцаж байв.
- ❖ Хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцах орчин бүрдүүлэх зорилгоор хичээлийн байруудад Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран үнэлгээ хийв. Оюутнуудтай харилцах мэргэжилтнүүдийг дохионы хэлний анхан шатны сургалтанд хамруулав. Зарим хичээлийн байруудад тэргэнцэр байрлуулж, налуу шат хийв.

Гадаад харилцааны чиглэлээр

Гадаадын төлөөлөгчтэй хийсэн уулзалт

- ❖ 2017.03.28 - БНТУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ахмет Язал



- ❖ 2017.03.30 - БНХАУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шин Хаймин
- ❖ 2017.04.10 - БНФУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Элизабет Барсак



- ❖ 2017.04.11 - БНПУ-а Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Михал Лабенда
- ❖ 2017.04.22 - АНУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны Олон нийттэй харилцах албаны даргын үүрэг гүйцэтгэгч Биатрис Кэмп
- ❖ 2017.05.02 - Япон улсын Сендай сангийн тэргүүн Ё.Оизүми, гүйцэтгэх захирал Э.Накашио
- ❖ 2017.05.16 - ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Сато Мүцүми



- ❖ 2017.07.18 - Берлин хот, муж улсын захирагч ба Сенатч Michael Müller болон Гумбольдтын их сургуулийн захирал Prof.Dr.-Ing. Dr. Sabine Kunst
- ❖ 2017.07.28 - Японы Чигагийн Технологийн сургуулийн Захирлуудын зөвлөлийн дарга Сэтокума Осаму



- ❖ 2017.11.01 - Япон улсын Хоккайдо их сургуулийн профессор Юкихиро Такахаши
- ❖ 2017.11.20 - БНФУ-ын ЭСЯ-ны элчин зөвлөх ноён Ален Дежак



- ❖ 2018.01.08 - Тохо их сургуулийн Хүндэт профессор Ф.Като
- ❖ 2018.02.08 - БНТУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Ахмет Язал



- ❖ 2018.02.22 - БНКУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ноён Раул Дэлгадо Консепсион
- 2018.03.13 - АНУ-н Анкорижийн Аласкийн Их сургуулийн Профессор Жон Даффи

Гадаад арга хэмжээ

- ❖ 2017.03.30 - БНХАУ-ын ЭСЯ-наас Ганжуур, данжуур хандивлах арга хэмжээ



- ❖ 2017.04.17 - “Монгол-Намянжу боловсролыг дэмжих сан”-гийн нарийн бичиг Кан Хан Сүнд МУИС-ийн ШУС-ийн ХҮНДЭТ ДОКТОР” цол гардуулах арга хэмжээ



- ❖ 2017.05.24 - Монгол-Солонгосын ЭЗ-ийн Форумын дэд Ерөнхийлөгч Жу Сонмүнд “ХҮНДЭТ ДОКТОР” цол гардуулах арга хэмжээ

Гадаад харилцааны чиглэлээр

- ❖ 2017.06.06-08 - Азийн их сургуулиудын 6-р форум



- ❖ 2017.06.12- МУИС-ийн ОУХНУС-ийн Хүндэт доктор Проф. Др. Штефан Ханселманнд “Найрамдал” медаль хүртсэнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ



- ❖ 2017.06.19- Монгол Улсын анхны “Мазаалай” хиймэл дагуулыг бүтээхэд дэмжлэг үзүүлсэн хандивлагчдад батламж гардуулав.



- ❖ 2017.10.05- МУИС-ийн 75 жилийн ойн хүрээнд гадаадын их сургуулиудын 47 зочин, Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагын 23 төлөөлөгчдийг хүлээн авав.

Хамтын ажиллагааны гэрээ


- ❖ 2017.05.10 - ОХУ-ын МГУ-тай “Ломоносов” төв байгуулах тухай гэрээ
- ❖ 2017.06.14 - БНСУ-ын Байгаль орчны Яамны харьяа Биологийн Нөөцийн Хүрээлэнтэй хамтын ажиллагааны гэрээ



- ❖ 2017.07.28 - Чива Технологийн сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг
- ❖ 2017.10.06 - БНПУ-ын Лоодзийн их сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг, БНСУ-ын Шиллагийн их сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг, ОХУ-ын Буриадын их сургуультай хамтын ажиллагааны тухай гэрээ
- ❖ 2017.10.24 - Токиогийн метрополитаны их сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг
- ❖ 2017.12.26 - Франц хэлтэн ИДС-ийн холбоотой хамтын ажиллагааны санамж бичиг

Санхүү, эдийн засгийн чиглэлээр

- ❖ 2017 онд бүрдүүлсэн орлогын дүн 47.5 тэрбум төгрөг байсан.



- ❖ Багш, ажилтны цалин хөлсийг нэмэх боломжийн талаар судалгаа хийж, үндсэн цалингийн түвшинг 10 хувиар нэмэх шийдвэр гаргуулан, мөрдөн ажиллаж байна.




- ❖ Үндсэн цалингийн сангийн 5 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллын санг бий болгож, МУИС-ийн багш, ажилтны урамшууллын сангийн суурийг тавьсан.



- ❖ Үндсэн болон эргэлтийн хөрөнгийг эзэмших, зөв зохистой ашиглах, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шилжүүлэх, худалдах, акталж, данснаас хасах, устгах үндсэн хөрөнгийн талаар дүгнэлт, санал гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцож, тайлагнах ажлыг зохион байгуулах зорилго бүхий “Өмч хамгаалах байнгын болон салбар зөвлөл” байгуулан ажиллаж байна.

- ❖ Төсвийн төлөвлөлтийг сайжруулах үүднээс “Төсөв боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг МУИС-ийн удирдлага, бүртгэл, санхүүгийн ажилтнуудад зориулан зохион байгуулсан.



- ❖ Бүрэлдэхүүн, салбар сургуулиуд, бие даасан нэгжүүдийн төсвийн гүйцэтгэлийг улирал, жилээр хянах, тайлагнах үйл явцыг нээлттэй, ил тод болгох зорилгоор уулзалтуудыг улирал тутам тогтмол зохион байгуулж, багш ажилтанд төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн талаарх мэдээллийг шууд хүргэдэг болгох үйл явцын эхлэлийг тавьсан.
- ❖ Төсвийн санхүүжилт нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллаж, БНХАУ, МУ-ын Засгийн газар хоорондын гэрээний дагуу 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой болсон бөгөөд зээлийн талаарх шаардлагатай бүх албан бичиг, төслийн баримт бичиг, санхүүжилтийн тооцоог хийж, холбогдох талуудад хүргүүлэн ажиллаж байна. 2018 онд улсын төсвөөс төслийн хүрээнд эхний ээлжийн 493.0 сая төгрөгийг авахаар улсын төсөвт тусгуулсан.

Санхүү, эдийн засгийн чиглэлээр

- ❖ Хичээлийн байруудын анги, танхимын үзлэг хийн, тухайн жилийн төлөвлөгөөт их болон урсгал засвар орох шаардлагатай объектуудыг тодорхойлж, нийт 65 анги танхим, сургалтын лабораторид засвар хийгдсэн.

Хичээлийн I байр үүдний хэсэг



Хичээлийн болон оюутны байрны газардуулга



ШУС-ийн засвар /гадна тохижилт



Хичээлийн II байрны 2-р давхарын вестибюлийн засвар тохижилт



- ❖ Хуучин номын сангийн зориулалтаар ашиглаж байсан, суларсан өрөө, тасалгааг хичээлийн анги, сургалтын болон судалгааны лаборатори, багш/судлаачдын ажлын өрөө болгон засварлах ажлыг зохион байгуулсан. Нийт 60 анги танхим, өрөө тасалгаа суларсан бөгөөд засварын дараах байдлаар сургалтын анги танхимын талбай 902.9м², сургалтын болон судалгааны лабораторийн талбай 1102.8м², багш/судлаачдын албан тасалгааны талбай 1207.8м²-аар тус тус нэмэгдэж, нийтдээ сургалтын зориулалтаар ашиглах талбайн хэмжээ 3213.5м²-аар өссөн.

Номын фондын өрөөг багш нарын өрөө болгосон (II байр 105 тоот танхим)



Номын сангийн өрөөг лаборатори болгон тохижуулсан (II байр 136 тоот заал)



Үдлэг дэх ойн судалгааны төв агаарын шугам, газардуулгын ажил



Сэлбэ зуслан дах багш, ажилчдын нийтийн бие засах газар, хогийн цэгийн засвар



Шинэ номын сан

- ❖ Шинэ номын сангийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласан.



- ❖ Тус барилга байгууламжийн ашигтай талбайн хэмжээ 13`200м² бөгөөд энэ хэмжээгээр сургалтын зориулалтын талбай нэмэгдсэн.
- ❖ Номын сангийн барилга нь хамгийн сүүлийн үеийн интерьер засал тохижилттой, олон улсын стандартад хүрсэн шинжлэх ухааны салбараар уншлагын танхим, цахим болон дижитал номын хэсэгтэй ажиллаж байна.
- ❖ Хурал (150-200 хүний багтаамжтай), семинар (100-150 хүний багтаамжтай)-ын 5 заал ашиглалтад орсон нь олон улсын болон дотоодын хурал, семинар, тэмдэглэлт үйл ажиллагааг зохион байгуулахад ихээхэн ач холбогдолтой болсон.



- ❖ Суралцагч, багш/судлаачид чөлөөт цагаа өнгөрөөх танхим, бие даан бүлгээр ажиллах өрөө, тасалгаа, магистрант, докторантуудын уншлагын танхим, ажиллах өрөө, Coffee shop, номын дэлгүүр, МУИС-ийн музей зэргээр үйлчлэх боломж бүрдсэн.
- ❖ 2017 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн МУИС-ийн бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хэмжээнд цахим материал унших үйлчилгээг нэвтрүүлсэн.
- ❖ Их, дээд сургуулиудын номын санчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргийнхээ хувьд их дээд сургууль болон ЕБС-ийн номын санчдын дунд хоёр удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан
- ❖ МУИС-ийн номын сангийн үйлчилгээг дэлхийн жишигт нийцсэн бүрэн автоматажсан номын сан болгох зорилгын хүрээнд технологийн шинэчлэлийн судалгааны баг гарч RFID технологийн судалгааг хийв.
- ❖ Цахим хэлбэрт шилжүүлж буй материал

№	Судалгааны бүтээл	Цаасан хэлбэрээр	Цахим хэлбэрт хөрвүүлсэн	Цахим хэлбэрт шилжсэн хувь
1	Магистрын ажил	6,187	3,140	50%
2	Диссертаци	684	-	-
3	Цахим ном	-	22	100%
4	Цахим сэтгүүл	-	2	100%

МУИС КАМПУС ТӨСӨЛ

- ❖ Барилга байгууламжаа шинэчлэн засварлах, шинээр барих боломжийн талаар судалгаа, хэлэлцүүлэг явуулж, МУИС-Кампус төсөл боловсруулан, 2017 оны 10-р сарын 5-нд “МУИС-Хөрөнгө оруулалтын форум” зохион байгуулан, төр, хувийн хэвшил, олон улсын донор байгууллага, элчин сайдын яамдуудад танилцуулав.



- ❖ Төсөлд хөрөнгө оруулалт, санхүүжилт босгох талаар уулзалтыг ЖАЙКА, Дуеллана ХХК, Голомт банк, МУИС-Төгсөгчдийн холбоо, МУИС-ЭЗС Төгсөгчдийн холбоо, Термигаз ХХК, Дуеллана групп зэрэг байгууллагуудтай хийж, эхний байдлаар санал солилцов.

